

**БАНК БУС САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГЫН САЛБАРЫН
2011 ОНЫ ГУРАВДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

2011.11.14

Улаанбаатар хот

**НЭГ. ББСБ-ЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
НЭГТГЭЛИЙН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТ**

2011 оны гуравдугаар улиралд Хороо нийт 5 компанид банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 3 компанийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор тайлант хугацааны эцэст нийт 192 компани санхүүгийн тайлан нэгтгэлд хамрагдлаа.

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр авсан компаниуд:

/Хүснэгт 1/

№	Компанийн оноосон нэр	Эрхлэх үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Ди Эй Эс Эс	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
2	Цагаан хас кредит	Зээл	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
3	Уянгацэрэн интернэшнл	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх
4	Дууш-Оргилуун	Зээл	Сэлэнгэ аймгийн Мандал суманд /Зүүнхараа/ үйл ажиллагаа эрхлэх
5	Эйч Кэй Эм Ай Би	Зээл, гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхлэх ба 100 хувийн БНХАУ-ын хөрөнгө оруулалттай

Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компаниуд:


/Хүснэгт 2/

№	Компанийн оноосон нэр	Эрхлэж байсан үйл ажиллагааны нэр төрөл	Нэмэлт мэдээлэл
1	Арвижих тив	Зээл, гадаад валютын арилжаа, төлбөрийн баталгаа гаргах	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан
2	Дэлгэрэх капитал	Гадаад валютын арилжаа	Дархан-Уул аймгийн Дархан суманд үйл ажиллагаа эрхэлж байсан
3	Жам зам	Гадаад валютын арилжаа	Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байсан

Мөн хугацаанд Авшиг-Одсэр ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авсан байна.

Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоог өмнөх онуудтай харьцуулвал:

/График 1/



2011 оны гуравдугаар улирлын санхүүгийн тайлан, мэдээний нэгтгэлийн голлох статистик үзүүлэлтүүдийг харуулбал:

/Хүснэгт 3/

№	Үндсэн үзүүлэлтүүд	2010 оны III улирал	2011 оны III улирал	Өсөлт +/, бууралт -/
1	ББСБ-ын тоо	187	192	5
2	Хувь нийлүүлэгчдийн тоо	587	599	12
3	Ажиллагсадын тоо	868	976	108
4	Салбар нэгжийн тоо	61	51	-10
5	Харилцагчдын тоо	110,399.0	137,376.0	26,977
6	Нийт актив /мянган төгрөгөөр/	121,755,609.3	189,103,738.2	67,348,129
Банкны салбарт эзлэх хувь		2.16%	2.31%	0.1%
7	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	73,760,183.5	107,940,478.3	34,180,295
Банкны салбарт эзлэх хувь		2.42%	2.15%	-0.3%
8	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	89,437,539.9	123,484,269.2	34,046,729
Банкны салбарт эзлэх хувь		31.38%	21.86%	-9.5%
9	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	78,212,683.3	105,730,915.0	27,518,232
Банкны салбарт эзлэх хувь		32.28%	42.39%	10.11%
10	Итгэлцлийн үйлчилгээний өглөг /мянган төгрөгөөр/	5,635,055.0	9,220,540.6	3,585,486
11	Нийт орлого /мянган төгрөгөөр/	21,275,481.0	31,690,990.2	10,415,509
12	Нийт зардал /мянган төгрөгөөр/	15,894,740.8	24,312,450.2	8,417,709
13	Тайлант үеийн ашиг /мянган төгрөгөөр/	5,380,740.1	7,378,540.0	1,997,800
1	Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ-ын тоо	15	16	1
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		7.98%	8.33%	0.4%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	19,183,852.1	27,186,510.3	8,002,658
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		15.76%	14.38%	-1.4%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	14,509,709.1	19,975,259.6	5,465,550
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		19.67%	18.51%	-1.2%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	7,907,526.0	14,013,385.8	6,105,860
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		8.84%	11.35%	2.5%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	8,267,792.5	11,150,932.5	2,883,140
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		10.57%	10.55%	-1.5%

2	Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	27	23	-4
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		14.36%	11.98%	-2.4%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	3,976,819.2	4,762,525.7	785,706
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		3.27%	2.52%	-0.7%
Б	Нийт зээлийн өрийн үлдэгдэл /мянган төгрөгөөр/	5,159,065.8	3,529,411.4	-1,629,654
ББСБ-ын нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь		6.99%	3.27%	-3.7%
В	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	3,623,652.0	4,392,543.6	768,892
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		4.05%	3.56%	-0.5%
Г	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	3,462,932.6	3,428,621.7	-34,311
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		4.43%	3.24%	-1.2%
3	Валютын арилжааны үндсэн үйл ажиллагаа явуулж буй ББСБ-ын тоо	49	42	-7
ББСБ-ын нийт тоонд эзлэх хувь		26.06%	21.88%	-4.2%
А	Нийт актив /мянган төгрөгөөр/	5,917,746.6	5,804,909.2	-112,837
ББСБ-ын нийт активт эзлэх хувь		4.86%	3.07%	-1.8%
Б	Нийт эзэмшигчдийн өмч /мянган төгрөгөөр/	5,877,383.7	5,680,795.1	-196,589
ББСБ-ын нийт эзэмшигчдийн өмчид эзлэх хувь		6.57%	4.60%	-2.0%
В	Нийт дүрмийн сан /хувьцаат капитал/ /мянган төгрөгөөр/	5,025,993.4	4,843,942.4	-182,051
ББСБ-ын нийт дүрмийн санд эзлэх хувь		6.43%	4.58%	-1.8%

Гадаадын хөрөнгө оруулалттай ББСБ:

2011 оны гуравдугаар улирлын байдлаар гадаадын 100 хувийн болон хамтарсан хөрөнгө оруулалттай 16 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 8.3 хувийг, тэдгээрийн нийт актив ББСБ-ын нийт активын 14.4 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-уудын олгосон зээлийн 18.5 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-уудын эзэмшигчийн өмчийн 11.3 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 10.5 хувийг тус тус эзэлж байна.

Гадаадын хөрөнгө оруулагчдын харьяаллаар нь авч үзвэл, Дэлхийн Зөн Олон улсын байгууллагаас санхүүжигдсэн 1, Япон улсын хөрөнгө оруулалттай 8, БНСУ-ын хөрөнгө оруулалттай 4, Итали, ОХУ, БНХАУ-ын хөрөнгө оруулалттай тус бүр 1 ББСБ үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

/Хүснэгт 4/

№	ББСБ-ын нэр	Гадаадын хөрөнгө оруулагчийн харьяалал	Гадаадын хөрөнгө оруулалтын хувь
1	Сар шинэ интернэшнл	Япон	46.3
2	Марико	Япон	95.0
3	Цагаан ажнай	Япон	100.0
4	Жи Си Ай Пи	Япон	28.6
5	Жэй эй эс эм	Япон	100.0
6	Фүжи холдинг	Япон	89.5
7	Монгорү матрикс гинго	Япон	100.0
8	Жэй си финанс	Япон	100.0
9	Мөнгөнбүрэн	БНСУ	29.0
10	Их түншлэл	БНСУ	75.0
11	Хос холбоо уул	БНСУ	100.0

12	Монгол пасифик	БНСУ	100.0
13	Вишн фонд	Зөн сан Монгол	100.0
14	Футур эволюшн	Итали	100.0
15	Монгол факторинг	ОХУ	23.9
16	Эйч Кэй Эм Ай Би	БНХАУ	100.0

Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ББСБ:

2011 оны гуравдугаар улирлын байдлаар орон нутагт төвтэй 23 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 12.0 хувийг, тэдгээрийн нийт актив нь нийт ББСБ-ын активын 2.5 хувийг, нийт олгосон зээл нь нийт ББСБ-ын олгосон зээлийн 3.3 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 3.6 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 3.2 хувийг тус тус эзэлж байна. Үүнд:

/График 2/



Валютын арилжааны үйл ажиллагаа дангаар эрхлэн явуулж буй ББСБ:

Валютын арилжаа дангаар эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 42 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаа нь нийт ББСБ-ын 21.9 хувийг, тэдгээрийн нийт актив нийт ББСБ-ын активын 3.1 хувийг, нийт эзэмшигчийн өмч нь нийт ББСБ-ын эзэмшигчийн өмчийн 4.6 хувийг, дүрмийн сан нь нийт ББСБ-ын дүрмийн сангийн 4.6 хувийг тус тус эзэлж байна.

ББСБ-уудыг Монгол Улсын Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуульд заасан үйл ажиллагаа, үйлчилгээ эрхэлж буйгаар нь ангилвал:

/Хүснэгт 5/

№	Үйл ажиллагааны нэр төрөл	Үйл ажиллагаа эрхэлж буй ББСБ-ын тоо	
		2010 оны III улирал	2011 оны III улирал
1	Зээл	138	147
2	Факторингийн үйлчилгээ	6	11
3	Төлбөрийн баталгаа гаргах	7	8
4	Төлбөр тооцооны хэрэгсэл гаргах	0	0
5	Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ	6	6
6	Гадаад валютын арилжаа	109	96
7	Итгэлцлийн үйлчилгээ	10	16
8	Богино хугацаат санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулалт хийх	2	3
9	Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх	9	13

10	Үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа	0	0
11	Хөрөнгө оруулалтын үйлчилгээ ¹ /Венчур хөрөнгө оруулалт/	1	1

ХОЁР. АКТИВЫН БҮТЭЦ, ЧАНАР, ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2.1 Активын бүтэц, өөрчлөлт:

ББСБ-ын салбарын 2011 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны нийт активын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд

/Хүснэгт 8/

№	ХӨРӨНГӨ	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Эргэлтийн хөрөнгө	116,896,770.6	96.0%	182,450,640.0	96.5%	65,553,869.4	56.1%
1	Мөнгөн хөрөнгө	34,772,760.3	28.6%	61,257,952.9	32.4%	26,485,192.6	76.2%
2	Богино хугацаат хөрөнгө оруулалт /цэврээр/	1,824,090.0	1.5%	3,264,416.9	1.7%	1,440,326.9	79.0%
3	Нийт зээл	73,760,183.5	60.6%	107,940,478.3	57.1%	34,180,294.7	46.3%
	(Зээлийн эрсдлийн сан)	3,917,222.5	3.2%	4,216,177.0	2.2%	298,954.6	7.6%
4	Нийт санхүүгийн түрээсийн тооцооны авлага	1,634,528.0	1.3%	2,237,285.0	1.2%	602,757.0	36.9%
	(Санхүүгийн түрээсийн эрсдлийн сан)	0.0	0.0%	0.0	0.0%	0.0	0.0%
5	Нийт факторингийн тооцооны авлага	365,564.2	0.3%	1,929,780.0	1.0%	1,564,215.8	427.9%
	(Факторингийн авлагын эрсдлийн сан)	350.0	0.0%	0.0	0.0%	-350.0	-100.0%
6	Өмчлөх бусад үл хөдлөх болон өмчлөх бусад хөрөнгө /цэврээр/	695,510.3	0.6%	532,987.2	0.3%	-162,523.2	-23.4%
7	Бусад хөрөнгө	7,761,706.7	6.4%	8,809,893.8	4.7%	1,048,187.1	13.5%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн авлага	0.0	0.0%	694,023.0	0.4%	694,023.0	100.0%
Б	Эргэлтийн бус хөрөнгө	4,858,838.6	4.0%	6,653,098.1	3.5%	1,794,259.5	36.9%
9	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө /цэврээр/	4,858,838.6	4.0%	6,653,098.1	3.5%	1,794,259.5	36.9%
	Үндсэн /биет/ ба биет бус хөрөнгө	6,426,723.2	5.3%	8,625,516.2	4.6%	2,198,793.0	34.2%
	(Хуримтлагдсан элэгдэл)	1,567,884.6	1.3%	1,972,418.0	1.0%	404,533.5	25.8%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		121,755,609.3	100.0%	189,103,738.2	100.0%	67,348,128.9	55.3%

2011 оны гуравдугаар улирлын байдлаар нийт актив өмнөх оны мөн үеэс 55.3 хувиар өсөхөд хуримтлагдсан ашиг 36.4 хувь, нийт өр төлбөр 103 хувь, дүрмийн сан 35.2 хувиар тус тус өссөн нь гол нөлөө үзүүлсэн байна.

Нийт активын 57.1 хувийг зээл, 32.4 хувийг мөнгөн хөрөнгө эзэлж дүнгээрээ нийт активын 89.5 хувийг бүрдүүлж байгаа нь ББСБ-ын салбарын гол үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа болохыг харуулж байна.

2.2 Зээлийн багцын чанар:

Зээлийн ангиллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад дараах байдалтай байна.

/Хүснэгт 9/

№	Ангилал	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь	Дүн /мян.төг/	Хувь
1	Хэвийн	66,293,185.2	89.9%	98,800,459.1	91.5%	32,507,273.9	49.0%
2	Хугацаа хэтэрсэн	1,958,797.1	2.7%	2,889,025.4	2.7%	930,228.3	47.5%
3	Чанаргүй зээл. Үүнээс	5,508,201.2	7.5%	6,250,993.7	5.8%	742,792.5	13.5%

Хэвийн бус	1,199,861.2	1.6%	1,662,697.7	1.5%	462,836.5	38.6%
Эргэлзээтэй	1,461,466.3	2.0%	1,529,837.5	1.4%	68,371.2	4.7%
Муу	2,846,873.7	3.9%	3,058,458.5	2.8%	211,584.8	7.4%
(Зээлийн эрдлийн сан)	3,917,222.5	5.3%	4,216,177.0	3.9%	298,954.6	7.6%
Нийт зээл	73,760,183.5	100.0%	107,940,478.3	100.0%	34,180,294.7	46.3%

2011 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны зээлийн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад, нийт зээлийн багц 46.4 хувиар өссөнөөс зээлийн багцад эзлэх хувийн жингээр хэвийн зээл 49.0 хувиар, чанаргүй зээл 13.5 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.


Өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад нийт зээлийн хэмжээ 34,180,294.7 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотойгоор чанаргүй зээлийн хэмжээ 742,792.5 мянган төгрөгөөр нэмэгсэн мэт харагдаж буй боловч нийт зээлийн дүнд эзлэх чанаргүй зээлийн хувь 5.8 хувь болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 1.7 хувиар буурч чанаржсан эерэг үзүүлэлттэй байна.

2.3 Зээлийн хүү:

Банк бус санхүүгийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэй нийт 192 ББСБ-аас 76,6 хувь буюу 147 ББСБ зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна. ББСБ-уудын зээлийн сарын хамгийн дээд хүү 10 хувь, хамгийн бага хүү 0.2 хувь байна.

Арифметик энгийн дунджаар тооцож үзвэл, нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж дээд хүү 3.8 хувь, зээлийн дундаж доод хүү 2.1 хувь буюу нийт ББСБ-ын зээлийн сарын дундаж хүү 2.9 хувь байна.

ББСБ-ын зээлийн хүүг банкны зээлийн хүүтэй харьцуулбал дараах байдалтай байна.



ГУРАВ. ПАССИВЫН БҮТЭЦ, ӨӨРЧЛӨЛТ

ББСБ-ын салбарын 2011 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны нийт өр төлбөр ба өөрийн хөрөнгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

/Хүснэгт 10/

№	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
A	Өр төлбөр	27,050,287.5	22.2%	51,070,116.5	27.0%	24,019,829.0	88.8%
1	Итгэлцлийн үйлчилгээний өглөг	5,635,055.0	4.6%	9,220,540.6	4.9%	3,585,485.7	63.6%
2	Дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагад төлөх өглөг	16,021,662.5	13.2%	33,910,198.5	17.9%	17,888,536.1	111.7%
3	Бусад эх үүсвэр	953,247.7	0.8%	2,814,332.6	1.5%	1,861,084.9	195.2%
	Зээлийн батлан даалтанд байршуулсан эх үүсвэр	1,059.3	0.0%	0.0	0.0%	-1,059.3	-100.0%
	Мөнгөн гуйвуулгын үйлчилгээний өглөг	910,235.8	0.7%	2,730,754.2	1.4%	1,820,518.3	200.0%
	Төлбөр тооцооны	3,007.0	0.0%	79,879.0	0.0%	76,872.1	2556.5%

Санхүүгийн зохицуулах хороо

Бичил санхүүгийн газар

	үйлчилгээний өглөг						%
	Факторингийн үйлчилгээний өглөг	35,246.3	0.0%	0.0	0.0%	-35,246.3	-100.0%
	Гадаад валютын арилжааны эх үүсвэр	3,699.4	0.0%	3,699.4	0.0%	0.0	0.0%
4	ББСБ-аас гаргасан өрийн бичиг	300,000.0	0.2%	400,000.0	0.2%	100,000.0	33.3%
5	Төслийн зээлийн санхүүжилт	4,140,322.4	3.4%	4,725,044.8	2.5%	584,722.4	14.1%
	Бусад өр төлбөр	5,267,781.9	4.3%	14,549,352.4	7.7%	9,281,570.6	176.2%
6	Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг	801,874.1	0.7%	2,533,822.6	1.3%	1,731,948.5	216.0%
7	Бусад пассив	4,465,907.8	3.7%	11,311,073.3	6.0%	6,845,165.6	153.3%
8	Санхүүгийн үүсмэл хэрэгсэл /дериватив/-ийн өглөг	0.0	0.0%	704,456.5	0.4%	704,456.5	100.0%
	Нийт өр төлбөр	32,318,069.4	26.5%	65,619,469.0	34.7%	33,301,399.6	103.0%
Б	Эзэмшигчдийн өмч	89,437,539.9	73.5%	123,484,269.2	65.3%	34,046,729.3	38.1%
9	Хувьцааг капитал	78,212,683.3	64.2%	105,730,915.0	55.9%	27,518,231.7	35.2%
10	Бусад өмч	942,681.8	0.8%	2,742,166.3	1.5%	1,799,484.5	190.9%
11	Сангууд	1,134,629.9	0.9%	1,130,538.6	0.6%	-4,091.2	-0.4%
12	Хуримтлагдсан ашиг/алдагдал	8,223,408.7	6.8%	11,216,135.1	5.9%	2,992,726.5	36.4%
13	Хоёрдогч өглөг /5 жилээс дээш хугацаатай/	924,136.3	0.8%	2,664,514.1	1.4%	1,740,377.8	188.3%
	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ	121,755,609.3	100.0%	189,103,738.2	100.0%	67,348,128.9	55.3%

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт өр төлбөр 103.0 хувиар, эзэмшигчдийн өмч 38.1 хувиар тус тус өссөн бөгөөд 2010 оны гуравдугаар улирлын тайлангаар нийт эх үүсвэрийн 26.5 хувийг нийт өр төлбөр, 73.5 хувийг эзэмшигчийн өмч эзэлж байсан бол 2011 оны гуравдугаар улиралд нийт өр төлбөр 34.7 хувь, эзэмшигчийн өмч 65.3 хувь болж өөрчлөгдсөн байна. Эх үүсвэрт эзлэх нийт өр төлбөр өссөн гол шалтгаан нь ББСБ-уудын итгэлцлийн үйлчилгээний өглөг, дотоод, гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хэмжээ өссөнтэй холбоотой.

Мөн банк бус санхүүгийн байгууллага шинээр нэмэгдэж иргэд, аж ахуйн нэгж байгууллагууд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх сонирхол нэмэгдсэнтэйгээр дүрмийн сан өсч байна.

Өөрийн хөрөнгийн эх үүсвэр нэмэгдсэн нь ББСБ-уудын өөрийн хөрөнгөөр эрсдэл даах чадварыг нэмэгдүүлж, улмаар санхүүгийн тогтвортой байдлын хувьд эерэг үзүүлэлт болж байна.

Өөрийн хөрөнгийн өсөлтөд Хорооны 2008 “Банк бус санхүүгийн байгууллагын дүрмийн сангийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 169 дүгээр тогтоолоор үүрэг болгосны дагуу ББСБ-ууд дүрмийн санг нэмэгдүүлсэн нь голлох үүрэг гүйцэтгэсэн.

ДӨРӨВ. ОРЛОГО, ЗАРЛАГА, АШИГТ АЖИЛЛАГАА

2011 оны гуравдугаар улирлын тайлант хугацааны нийт орлого өмнөх оны мөн үеэс 49 хувиар өссөн ба дараах үндсэн бүтэцтэй байна.

/Хүснэгт 11/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
	ХҮҮГИЙН ОРЛОГО	14,828,780.4	69.7%	21,311,060.5	67.2%	6,482,280.1	43.7%
1	Хугацаандаа байгаа зээлийн хүүгийн орлого	13,936,455.5	65.5%	19,744,428.6	62.3%	5,807,973.2	41.7%
	Хугацаа хэтэрсэн зээлийн хүүгийн орлого	530,469.7	2.5%	428,326.7	1.4%	-102,143.0	-19.3%
	Үнэт цаасны хүүгийн орлого	44,250.8	0.2%	0.0	0.0%	-44,250.8	-100.0%

Санхүүгийн зохицуулах хороо

Бичил санхүүгийн газар

	Бусад хүүгийн орлого	317,604.4	1.5%	1,138,305.1	3.6%	820,700.7	258.4%
2	ХҮҮГИЙН БУС ОРЛОГО	5,872,744.3	27.6%	9,766,565.9	30.8%	3,893,821.6	66.3%
3	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	512,657.0	2.4%	606,765.6	1.9%	94,108.6	18.4%
4	ЕРДИЙН БУС ОРЛОГО	61,299.3	0.3%	6,598.2	0.0%	-54,701.1	-89.2%
	НИЙТ ОРЛОГО	21,275,481.0	100.0%	31,690,990.2	100.0%	10,415,509.2	49.0%

Нийт орлого өмнөх оны мөн үеэс 49 хувиар өссөн нь ББСБ-уудын эзэмшигчдийн өмчийн өсөлт, бусдаас татсан эх үүсвэрийн өсөлттэй шууд холбоотой бөгөөд нийт орлогын өсөлтөд үндсэн үйл ажиллагааны орлого болох хүүгийн орлого гол хувийг эзэлж байна.

Хүүгийн бус орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 66.3 хувиар өссөн байна. Үүнд:

/Хүснэгт 12/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	Арилжааны орлого	1,512,518.2	25.8	4,108,055.0	42.1	2,595,536.8	171.6
1.1	Гадаад валютын арилжааны орлого	1,512,518.2	25.8	3,605,482.9	36.9	2,092,964.7	138.4
1.2	Үнэт цаасны арилжааны орлого	0.0	0.0	502,572.1	5.1	502,572.1	100.0
2	Ханш болон үнэлгээний тэгшитгэлийн орлого	3,017,770.6	51.4	3,654,258.3	37.4	636,487.7	21.1
2.1	Гадаад валютын ханшийн тэгшитгэлийн орлого	3,017,770.6	51.4	3,649,718.0	37.4	631,947.4	20.9
2.2	Үнэт цаасны үнэлгээний тэгшитгэлийн орлого	0.0	0.0	4,540.3	0.0	4,540.3	100
3	Санхүүгийн үйлчилгээний орлого	1,342,455.6	22.9	2,004,252.7	20.5	661,797.1	49.3
3.1	Санхүүгийн түрээсийн орлого	24.1	0.0	4,364.4	0.0	4,340.2	100.0
3.2	Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,116.0	0.0	2,032.1	0.0	916.1	82.1
3.3	Мөнгөн гуйвуулгын орлого	469,251.0	8.0	546,861.3	5.6	77,610.3	16.5
3.4	Картын үйлчилгээний орлого	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
3.5	Санхүүгийн зөвлөгөө, мэдээлэл өгөх үйлчилгээний орлого	50,805.5	0.9	66,100.5	0.7	15,295.0	30.1
3.6	Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	488,706.2	8.3	967,486.3	9.9	478,780.1	98.0
3.7	Бусад	332,552.7	5.7	417,408.1	4.3	84,855.4	25.5
	НИЙТ	5,872,744.3	100.0	9,766,565.9	100.0	3,893,821.6	66.3

Нийт зардлын бүтцүүд дараах байдалтай байна.

/Хүснэгт 13/

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.09.30		2011.09.30		Өөрчлөлт	
		Дүн	Хувь	Дүн	Хувь	Дүн	Хувь
1	ХҮҮГИЙН ЗАРДАЛ	1,720,105.2	10.8%	3,634,308.3	14.9%	1,914,203.0	111.3%
2	ХҮҮГИЙН БУС ЗАРДАЛ	11,646,126.2	73.3%	17,350,960.0	71.4%	5,704,833.8	49.0%
3	БОЛЗОШГҮЙ ЭРСДЭЛИЙН ЗАРДАЛ	1,601,622.9	10.1%	1,918,631.2	7.9%	317,008.3	19.8%
4	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	213,976.4	1.3%	429,200.7	1.8%	215,224.3	100.6%
5	ЕРДИЙН БУС ЗАРДАЛ	30,753.3	0.2%	193.2	0.0%	-30,560.1	-99.4%
6	ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ	682,156.7	4.3%	979,156.8	4.0%	297,000.1	43.5%
	НИЙТ ЗАРДАЛ	15,894,740.8	100.0%	24,312,450.2	100.0%	8,417,709.4	53.0%

Нийт зардал өмнөх оны мөн үеэс 53 хувиар өссөн нь ББСБ-уудын бусдаас татсан эх үүсвэрт төлөх хүүгийн зардал 111.3 хувиар өссөн байгаа нь шууд нөлөө үзүүлсэн байна.

ББСБ-ууд нь 2011 оны гуравдугаар улиралд нийт 7,378,540.0 мянган төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 37.1 хувийн өсөлттэй байна.

№	ҮЗҮҮЛЭЛТҮҮД	2010.09.30	2011.09.30	Өөрчлөлт
		Дүн	Дүн	Дүн
1	НИЙТ ОРЛОГО	21,275,481.0	31,690,990.2	10,415,509.2
2	НИЙТ ЗАРДАЛ	15,894,740.8	24,312,450.2	8,417,709.4
3	ТАТВАРЫН ДАРААХ ЦЭВЭР АШИГ	5,380,740.1	7,378,540.0	1,997,799.8

ТАВ. САЛБАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

ББСБ-ын салбарын санхүүгийн тайлангийн нэгтгэлээр Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-аар тогтоосон үзүүлэлтүүд нэгтгэлийн түвшинд дараах байдалтай байна. Үүнд:

- нийт өөрийн хөрөнгө 123,484,269.2 мянган төгрөг, эрсдэлээр жигнэсэн актив 125,604,974.9 мянган төгрөг байгаагаас өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааны шалгуур үзүүлэлт нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хувьд 95.9 хувь, өөрийн хөрөнгийн хувьд 98.3 хувь, нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, нийт активын хувьд 63.7 хувь;

- түргэн борлогдох актив 64,001,131.5 мянган төгрөг, бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө 42,389,090.5 мянган төгрөг байгаагаас төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 150.9 хувь;

- валютын дансны цэвэр зөрүү 6,455,198.1 мянган төгрөг, валютаарх өөрийн хөрөнгө 123,484,269.2 мянган төгрөг байгаагаас гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа 5.23 хувь;

- итгэлцлийн үйлчилгээгээр татан төвлөрүүлсэн өглөгийн үлдэгдэл 9,220,540.6 мянган төгрөг, хувьцаат капитал 105,730,915.0 мянган төгрөг байгаагаас итгэлцлийн үйлчилгээний өглөг, хувьцаат капиталын харьцаа 8.7 хувь;

- нийт цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө 2,120,685.6 мянган төгрөг, нийт актив 189,103,738.1 мянган төгрөг байгаагаас үндсэн хөрөнгө, нийт активын харьцаа 1.1 хувь байгаа нь салбарын хэмжээнд дээрх зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тус тус хангасан байна.

Харин активын эрсдэлийн санг 4,383,502.9 мянган төгрөгөөр байгуулбал зохихоос 167,325.9 мянган төгрөгөөр дутуу буюу нийт 4,216,177.1 мянган төгрөгөөр байгуулсан байна.²

Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу ангилж зээлийн эрсдэлийн санг бүрэн байгуулах шаардлагатай байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ

1. ББСБ-уудын дийлэнх хэсэг нь зээл, гадаад валютын үйл ажиллагааг дагнан болон зэрэг эрхлэж байна. Нэр бүхий 23 ББСБ банк бус санхүүгийн үйл ажиллагааны төрлүүдээс 3-4 –ийг зэрэг эрхлэхээр тусгай зөвшөөрөл эзэмшиж байна. ББСБ-ын хувь нийлүүлэгчдийн хөрөнгө санхүүгийн чадвараас хамаарч үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх хандлага сул байна.

Харин гадаадын хөрөнгө оруулалтай болон томоохон банк бус санхүүгийн байгууллагууд нэмэгдэхийн хэрээр банк бус санхүүгийн хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө мэдээлэл өгөх факторингийн болон итгэлцэлийн үйл ажиллагаа эрхлэх ББСБ тоо өсөх хандлагатай байна.

² Энэхүү тоон үзүүлэлтийг гаргахдаа тухайн ББСБ-уудын ТОП20 зээлдэгчийн мэдээлэлд тулгуурлан гаргасан болно.
ББСБ-ын салбарын 2011 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нэгтгэлийн танилцуулга

2. ББСБ-уудын голлох үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт актив 67,348,129.9 мянган төгрөг буюу 55.3 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 34,180,294.8 мянган төгрөг буюу 46.3 хувь, эзэмшигчийн өмч 34,046,729.3 мянган төгрөг буюу 38.1 хувь, нийт дүрмийн сан 25,518,231.7 мянган төгрөг 35.2 хувиар тус тус өссөн байна.
3. ББСБ-уудын нийт актив 2011 оны гуравдугаар улирлын байдлаар 189,103,738.2 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт активын **/банкны салбарын нийт актив 8,192,724,550.3 мянган төгрөг/** 2.3 хувь, нийт зээлийн өрийн үлдэгдэл 107,940,478.3 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт зээлийн **/банкны салбарын нийт зээл 5,020,232,370.9 мянган төгрөг/** 2.1 хувь, чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 6,250,993.7 мянган төгрөг байгаа нь банкны салбарын чанаргүй зээлийн **/банкны салбарын чанаргүй зээл 354,254,648.7 мянган төгрөг/** 1.8 хувь, нийт дүрмийн сан 105,730,915.0 мянган төгрөг байгаа нь банкны салбарын нийт дүрмийн сангийн **/банкны салбарын нийт дүрмийн сан 249,432,366.8 мянган төгрөг/** 42.4 хувьтай тус тус тэнцэж байна.

БИЧИЛ САНХҮҮГИЙН ГАЗАР